



ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 7/53

Тавин


Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Хог тээврийн авто машин худалдан авах ДУГААСЗДТГ/2023/01014 ажлын гүйцэтгэгчээр "Арби элеваторс" ХХК-г сонгон гэрээ байгуулсугай.
2. Уг ажлыг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу гэрээний хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийг "Арби элеваторс" ХХК-ны захирал (Э.Уртнасан)-д даалгасугай.
3. Гэрээт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ч.Оюунцэцэг), Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Уранцэцэг) наарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.УРАНЧИМЭГ



БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АДААЦАГ СҮМЫН ЗАСАГ
ДАРГА. ЧУРАНЧИМЭГ

ХОГ ЗӨӨВРИЙН АВТОМАШИН ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2023.06.07

Дугаар №
ДУГААСЗДТГ/202301014

Тавин

ГҮЙЦЭТГЭГЧ RB
“АРБИ ЭЛЕВАТОРС” ХХК ИЙН
ЗАХИРАЛ ЭУРТНАСАН



Нэг. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1.1. Нэг талаас Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын Тамгын газар (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Арби Элеваторс” ХХК (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1.2. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн дагуу хог хаягдлын талаарх төрийн бодлогын хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, биелэлтийг хангахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.3. Захиалагч нь Дундговь аймгийн Адаацаг суманд “ХОГ ЗӨӨВРИЙН АВТОМАШИН ХУДАЛДАН АВАХ” ажлыг (цаашид “ажил” гэх) **85,160,000 [Наян таван сая нэг зуун жаран мянга]** төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн үнийг үүгээр хулээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

1.4. Гэрээний нийт дүн: **85,160,000** төгрөг.

1.5. Гүйцэтгэгч “Арби Элеваторс” ХХК нь Дундговь аймгийн Адаацаг суманд “ХОГ ЗӨӨВРИЙН АВТОМАШИН ХУДАЛДАН АВАХ” ажлыг **2023 оны 06 дугаар сарын 10-ны өдөр эхэлж, 2023 оны 07 дугаар сарын 10-ны өдрийг** дуустал хийж гүйцэтгэнэ.

1.6. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний бичиг баримт” гэх). Үүнд:

- a) Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- b) Гэрээний ерөнхий нөхцөл
- c) Гэрээний тусгай нөхцөл
- d) Техникийн тодорхойлолт
- e) Ажил гүйцэтгэх хуваарь
- f) Бусад шаардлагатай баримт бичиг
- g) Санхүүжилтийн хуваарь

1.7. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

1.8. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

1.9. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзод нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах уурэг хариуцлагыг хүлээж байна.

1.10. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хулээж байна.

1.11.Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

Хоёр. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ , ҮҮРЭГ

2.1. Захиалагч нь /Адаацаг ЗДТГ/ гүйцэтгэгчээс /“Арби Элеваторс” ХХК/ гэрээтэй
эжлийн санал болон эсийн гүйцэтгэлийн тайланг гаргуулан авах эрхтэй.

2.2. Захиалагч нь гүйцэтгэлийн ажлын явцад уүссэн саад бэрхшээлийн улмаас гэрээт ажил хийгдээгүй буюу дутуу хийгдсэн тохиолдолд олгосон санхүүжилтийг бичсан нэхэмжлэх эрхтэй /Байгалийн давагдашгүй хүчин зүйл нөлөөллөөс бусад/.

2.3. Гэрээнд тусгасан ажлын явцад хяналт тавьж, гүйцэтгэлийг ажил хүлээн авах комиссын актаар баталгаажуулан хүлээн авч дүгнэнэ.

2.4. Захиалагч нь гүйцэтгэгчээс доорх материалуудыг бүрдүүлэн авна. Үүнд:

1. Ажил гүйцэтгэсэн тайлан, фото зургаар баримтжуулсан байх
 2. Ажил худалдаан авах комиссын акт

2.5. Захиалагч ажлын гүйцэтгэлийн байдалд хяналт тавин ажиллаж, үнэлгээ хийнэ.

2.6. Гүйцэтгэгчид ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх шаардлага тавих эрхтэй.

2.7. Захиалагч нь гэрээнд заасны дагуу санхүүжилтийг олгох үүрэгтэй. Үүнд: гэрээ байгуулсаны дараа урьдчилгаа төлбөр 0 буюу төгрөг, гэрээг хэрэгжүүлж 2023 онд үйлдвэрлэгдсэн шинэ, захиалагчийн тавьсан техникийн тодорхойлолтонд заасан "Хог зөөвөрлөх автомашин"-ыг хүлээн авах комиссын актаар баталгаажуулан хүлээн авч, захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөний дараа гэрээний 100 % буюу үлдэгдэл/нийт санхүүжилт **.85.160.000** төгрөгийг ажлын 7 хоногт багтаан гүйцэтгэгчид олгоно.

Гэрээт ажлыг үе шатны хуваарийн дагуу цаг хугацаанд хийж гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05 хувиар алданги тооцно.

Гурав. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Гүйцэтгэгч нь нь Адаацаг суманд “Хог зөөвөрлөх автомашин нийлүүлэх” ажлыг техникийн тодорхойлолтод заасны дагуу цаг хугацаанд нь чанартай сайн хийж гүйцэтгэх үүрэгтэй.

3.2 Гүйцэтгэгч нь гэрээний хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

1.2023 онд үйлдвэрлэгдсэн шинэ, захиалагчийн тавьсан техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн "Хог зөөверлөх автомашин"-ыг шаардагдах бичиг баримтын хамт суманд өөрийн зардлаар хүргэж хулээлгэн өгнө.

хүлээлгэн өгнө.
2.Гүйцэтгэгч нь нийлүүлсэн “Хог зөөвөрлөх автомашин”-д 1 жилийн техникийн баталгаа гаргаж, техникийн баталгаанд заагдсан эд ангиудад эвдрэл гарсан тохиолдолд цаг хугацаа алдалгүй засвар үйлчилгээг хийж агне.

3. Гүйцэтгэгч нь автомашин нийлүүлэх ажлын явцыг фото зургаар баримтжуулан тайлан гарган өгч, автомашиныг ажил хүлээн авах комисст хүлээлгэн өгч актаар баталгаажуулна.

Дөрөв. ЗАХИАЛАГЧ, ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХАРИЛЦАН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

4.1. Гэрээний аль нэг тал үүргээ ноцтой зөрчсөн бол Иргэний хуулийн 225, 226 дугаар зүйлүүдэд заасан үндэслэл, журмын дагуу нөгөө тал гэрээг цуцалж, учирсан хохирлоо төлүүлэхээр шаардах эрхтэй.

4.2. Гэрээний үүргээ биелүүлээгүй, хоёр тал харилцан тохиролцоонд хүрээгүй тохиолдолд хуулийн дагуу харьяаллын шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.3. Энэхүү гэрээг гурван хувь үйлдэж, захиалагч, гүйцэтгэгч тус бүр нэг хувийг хадгалж, бусад хувийг холбогдох газарт өгнө.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АДААЦАГ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ *Оюун* Ч.ОЮУНЦЭЦЭГ

Хаяг: АДААЦАГ СҮМ 1-Р БАГ
Утас: 99021494



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“АРБИ ЭЛЕВАТОРС” ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Э.УРТНАСАН

Хаяг: Улаанбаатар хот
Утас: 91919824
Харилцагч банкны нэр: Голомт банк
дансны дугаар: 1415133210





2023 оны 03 сарын 06

Мандалговь хот

**АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ НИЙЛҮҮЛЭГДЭХ
ХОГ ТЭЭВРИЙН АВТО МАШИНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

| Техникийн үзүүлэлт | Техникийн тодорхойлолт болон стандарт |
|------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Машины зориулалт | Ачаа өөрөө буулгагч авто машин |
| Загвар | Yue jin |
| Чанарын түвшин | 2022 онд үйлдвэрлэсэн 00 гүйлттэй гидро хүчлүүрт жолооны хурдтай, хийн тормозтой, халаагчтай, эир кондэйшннтэй |
| Зориулалт | Ахуйн хатуу хог хаягдал түр хадгалах, тээвэрлэх, тусгай зориулалттай |
| Хөдөлгүүрийн багтаамж | 5900 cc-ээс дээш, дизель |
| Хурдны хайрцаг | 5 урагшаа Араа, 1 урвуу, синхрон |
| Машины хэмжээ | 7600*2500*2950 мм |
| Тэвшний хэмжээ | 4480*2210*1400 мм |
| Тэнхлэг хоорондын зайд | 4200-с багагүй |
| Газраас тэнхлэг хоорондын зайд | 300мм |
| Даац | 8-10тн |
| Тоормозны систем | Бүрэн агаарын тоормосны систем, хуваах хийн хэлхээний /6+1 нэгж/, 11.00 R2 0 |
| Дугуйн хэмжээ, тодорхойлолт | |
| Баталгаат хугацаа | 24 сар |
| Шатахууны зарцуулалт | 25 /100км-т/ |
| Бүх жин | 6000кг-аас доошгүй |
| Машины өнгө | Сувдан цагаан /машины кабин болон тэвш нь/ |
| Дагалдах бичиг баримт, иж бүрдэл | Үйлдвэрээс дагалдах сэлбэгийн кодтой ном, моторын ном, үйлчилгээ хийх заавар улсын дугаар авч даатгал оношилгоонд хамрагдаж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, гаалийн бичгийн нотариатаар батлуулсан хуулбартай/, 8 тн-ын даацтай домакрад, түлхүүр багажны иж бүрдэл, дугуйн дорцов болон 1 ээлжийн солих ком шүүртэй /тос, тулшиний шүүр, агаар шүүгч, эхний удаа бүрэн үйлчилгээ хийхэд шаардагдах моторын тос 20л, тосол 40л, гидрийн шингэн 40л, Суудлын бүрээстэй. |
| Машины нэмэлт тоноглол, төхөөрөмж. | Тухайн машины сэлбэг хэрэгсэл нь Монголд зарагддаг байх. Гидро өргөгчтэй байх. /уг төхөөрөмж нь машины хажуу талд бэхлэгдсэн байх./ |

Үнэ тоо хэмжээ:

| д/ д | Авто машины загвар | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ /төгрөг/ | Нийт үнэ /төгрөг/ | Тайлбар |
|---------|-----------------------------------------------|----------------|---------------|----------------------------|----------------------|-------------------------------------------------|
| 1 | Хог тээврийн зориулалттай машин Yue jin | ш | 1 | 90.000.000 | 90.000.000 | Техникийн үзүүлэлтийг бүрэн хангасан байх |



ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 2/23

Тавин

Хог зөөврийн автомашин худалдах авах
ажлыг хүлээн авах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Хог зөөврийн автомашин худалдан авах” ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Алтансарнай (Төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд: Б.Хаданчулуун (Тамгын газрын Жолооч)

Ч.Урантуяа (Тамгын газрын Нярав)


Ө.Уранбилэг (Тамгын газрын Нягтлан бодогч)

Ж.Даваахүү (Тамгын газрын Слесарь)

2. Дээрх ажлыг актаар хүлээн авч, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.УРАНЧИМЭГ



Сангийн сайдын 2016 оны
12 дугаар сарын 22-ны өдрийн
415 дугаар тушаалын 7-р хавсралт

АВТО МАШИН ХҮЛЭЭН АВСАН
КОМИССЫН АКТ

2023.07.06

Дугаар: 3

Тавин

НЭГ.

- 1.1 Гэрээний нэр, дугаар, огноо: "Хог зөөврийн автомашин нийлүүлэх" №ДУГААСЗДТГ/202301014
- 1.2 Тоног төхөөрөмжийн нэр, хүчин чадал: Dongfeng үйлдвэрийн 10 тн-ын даацтай, дизель хөдөлгүүртэй, 2023 онд үйлдвэрлэгдсэн өөрөө буулгагч авто машин 1 ширхэг.
- 1.3 Захиалагч байгууллага: Адаацаг сумын Засаг даргын Тамгын газар
- 1.4 Нийлүүлэгч байгууллага: "Арби элеваторс" ХХК
- 1.5 Сумын Засаг даргын 2023 оны 07 дүгээр сарын 06-ны өдрийн А/73 тоот захирамжаар байгуулагдсан 5 хүний бүрэлдэхүүнтэй бараа хүлээн авах комисс нь захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ДУГААСЗДТГ/202301014 гэрээний дагуу нийлүүлэх авто машиныг гэрээний хавсралт, ерөнхий болон тусгай нөхцөлд тусгагдсан шаардлагыг хангасан байдал, барааны чанар, тээвэрлэлт, хадгалалтын байдал болон авто машины холбогдох баримтуудтай газар дээр нь танилцаж, шалган үзэв.
- 1.6 Авто машиныг 2023 оны 07дугаар сарын 06-ны өдөр бүрэн хүлээлгэн өгч дууссан байна..

ХОЁР.

- 2.1 Авто машиныг шалгаж үзээд, гүйцэтгэгч байгууллага гэрээний дагуу нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн гэж үзлээ.
- 2.2 Авто машиныг захиалагч байгууллагын мэдэлд бүрэн шилжүүлж, ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэв.
- 2.3 Авто машиныг хүлээн авах комиссын акт, холбогдох баримт бичиг, материалыг 3 хувь үйлдэж, захиалагч, гүйцэтгэгч, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус бүрт 1 хувийг хургуулна.
- 2.4 Энэ актаар хүлээн авсан авто машины бүх баримт бичиг нь дараах зүйлээс бурдэнэ. Үүнд:
 - a)Авто машины дагалдах техникийн бусад баримт материал:

б) Баталгаат засварын хугацаа, бичиг баримт:

в) Гарын авлага

г/.Галын хор

д/ Эмийн сан

ГУРАВ.

| № | Нэр төрөл | Үзүүлэлт | Үйлдвэрлэсэн улс, байгууллага, огноо | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|-----|---------------------------------------------|----------------------------|--------------------------------------------|----------------|----------------|-------------|
| 1 | Өөрөө буулгагч хог тээврийн автомашин | Dongfeng 10тн 2023он | БНХАУ | 1 | 85.160 000₮ | 85.160.000₮ |
| 2 | Арлын дугаар | LGDCH81D 6PH100735 | | | | |
| Дүн | | | | | | 85.160.000₮ |

КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН:

Комиссын дарга: Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн
мэргэжилтэн

Сердээс

Ц.Алтансарнай

Гишүүд: ЗДТГ-ын жолооч

Ходончихээр

Б.Хаданчулуун

Нярав

Ч.Урантуяа

Ч.Урантуяа

Нягтлан бодогч

Ө.Уранбилэг

Ө.Уранбилэг

Слесарь

Ж.Даваахүү

Ж.Даваахүү

Гүйцэтгэгч:

“Арби элеваторс” ХХК-ийн захирал
Менежер



Э.Уртнасан
Б.Өнөрбаяр